

**ЕБС-ИЙН БАГА АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ СУРАХ БИЧИГ ДЭХ
УРАН ЗОХИОЛЫН НЭР ТОМЬЁНЫ ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭГ
ЦАХИМ ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ҮҮДНЭЭС БҮРТГЭСЭН НЬ¹**

Т.Батбямба
Г.Нарантунгалаг
Э.Уранбилэг
Ч.Алтангэрэл

Хураангуй: Бид тус өгүүлэлдээ Монгол Улсын ЕБС-ийн I-V ангийн Монгол хэлний сурах бичгийг хэрэглэгдэхүүн болгон нийт үгийн сангаар цахим сан үүсгэсэн бөгөөд уг санд тулгуурлан Японы Антони Лауренсийн AntConc² хэрэгсэл болон МУИС-ийн Хэрэглээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн Сургуулийн (Ч.Алтангэрэл, Ж.Пүрэв) “Кирилл монгол бичвэрийн дуудлагын хөрвүүлгийн программ”-ыг ашиглан уран зохиолын нэр томьёог бүртгэн, давтамжийг тооцоолохын зэрэгцээ сурах бичиг тус бүрд нь болон хооронд нь харьцуулж, тогтвортой хэрэглээг тодорхойлохыг зорьсон болно.

Түлхүүр үг: *Сурах бичиг, цахим хэл шинжлэл, нэр томьёо*

Удиртгал

Монгол хэлний сурах бичиг бол хүүхдийн унших, ярих, сонсох, бичих, хэлзүй, үгийн сангийн хэрэглээний чадварыг эзэмшүүлэхэд чухал үүрэгтэй хэрэглэгдэхүүн бөгөөд уг сурах бичгийн агуулга, арга зүйг судалсан судалгааны бүтээл харьцангуй олон байдаг боловч, бага ангийн монгол хэлний сурах бичиг дэх уран зохиолын нэр томьёо нь хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон эсэх, тухайн нэр томьёоны тайлбарыг онол-арга зүйгээр хялбаршуулсан эсэх зэрэг асуудалд чиглэсэн нарийвчилсан судалгаа цөөн байгааг харгалзан энэ төрлийн судалгааг хийх зайлшгүй шаардлага бидний өмнө тулгараад байгаа билээ. Иймд бид тус судалгаагаа БШУЯ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол хэлний стандарт шалгалт, программ хангамж боловсруулах төсөл”-ийн хүрээнд бүрдүүлсэн *Монгол хэл I* сурах бичгийн 6780, *Монгол хэл II* сурах бичгийн 20430, *Монгол хэл III* сурах бичгийн 28639, *Монгол хэл IV* сурах бичгийн 38435, *Монгол хэл V* сурах бичгийн 30923 үгтэй үгийн сангийн цахим хөмрөгт тулгуурлан хийв.

Судалгааны зорилго: Монгол улсын ЕБС-ийн бага ангийн монгол хэлний сурах бичгийн судалгааг цаашид улам нарийвчлах хэд хэдэн бодит шаардлага гарч байна. Юуны өмнө сурах бичгийн цахим санг бүрдүүлсний үндсэн дээр уран зохиолын нэр томьёоны тогтвортой хэрэглээг нарийвчлан тогтоох зорилго тавив.

¹ БШУЯ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол хэлний стандарт шалгалт, программ хангамж боловсруулах төсөл”-ийн хүрээнд бичив.

² Anthony, L. (2021). AntConc (Version 4.0.2) [Computer Software]. Tokyo, Japan: Waseda University. Available from <https://www.laurenceanthony.net/software>

Ийм хэлбэрийн судалгаа нь цаашид монгол хэлний сурах бичгийн үгийн сангийн нэр томъёоны тооцооллыг хийхэд ач холбогдолтой гэж үзэж байна.

Судалгааны арга: Энэхүү судалгааны үндсэн арга нь сурах бичгүүдийн нийт үгийг цахим хувилбарт оруулж сан үүсгэх бөгөөд тус сангаас хөмрөгийн хэл шинжлэлийн хэрэгсэл ашиглан давтамж гаргаж тооцоолол хийх аргыг ашиглав. Ингэхдээ мөн хам бичвэрийн арга, хам сэдвээс үгсийг ялгах аргыг хослуулан хэрэглэсэн нь уран зохиолын нэр томъёоны тогтвортой хэрэглээг тодорхойлж, сурах бичиг дэх давтамжид суурилж дүгнэлт ажиглалт хийх боломж бүрдсэн юм. Мөн туршилтын, анализ ба синтезийн зэрэг бусад аргыг хэрэглэв.

Судалгааны хэрэглэгдэхүүн: Тус судалгаанд Монгол Улсын БСШУСЯ-ны хүлээн зөвшөөрсөн Ш.Оюунцэцэг, Ө.Хадаа, Д.Цогцолмаа, Т.Энхтуяа *Монгол хэл I*. Уб., 2020 (долоо дахь хэвлэл), 172 тал; Г.Бямбацэрэн, Г.Болормаа, Б.Лхамноржмоо, В.Хажидмаа *Монгол хэл II*. Уб., 2020 (долоо дахь хэвлэл) 152 тал; Ө.Цэндсүрэн, Р.Бигэрмаа, П.Жаргалсайхан, У.Нямхүү *Монгол хэл III*. Уб., 2020 (долоо дахь хэвлэл) 152 тал; П.Одсүрэн, Б.Гэрэлсайхан, Н.Даваасүрэн, Ц.Дашдолгор *Монгол хэл IV*. Уб., 2020 (долоо дахь хэвлэл), 152 тал; Л.Олзвой, Б.Оюунцэцэг, М.Энхжаргал, Ш.Оюунцэцэг *Монгол хэл V*. Уб., 2020 (долоо дахь хэвлэл) 152 тал хэвлэлийг хэрэглэгдэхүүн болгов. Дээрх сурах бичгүүдийг зарж борлуулахыг хориглосноос гадна зөвхөн сургуулийн номын сангаар дамжуулан сурагчдад үнэ төлбөргүй олгодог байна.

Судалгааны хэсэг

Бид “Монгол хэлний стандарт шалгалт, программ хангамж боловсруулах төсөл”-ийн хүрээнд үүсгэсэн *Монгол хэл I* сурах бичгийн 6780, *Монгол хэл II* сурах бичгийн 20430, *Монгол хэл III* сурах бичгийн 28639, *Монгол хэл IV* сурах бичгийн 38435, *Монгол хэл V* сурах бичгийн 30923 үгтэй үгийн сангийн цахим хөмрөгтөө тулгуурлан өмнө хийгдсэн сурах бичгийн болоод нэр томъёонд холбогдох судалгаануудаас өргөн хүрээнд ажилладаг тооцооллын программуудыг ашиглан бага ангийн монгол хэлний сурах бичгүүд дэх уран зохиолын нэр томъёог дараах хэд хэдэн талаас бүртгэн тооцоолсон юм. Үүнд:

Сурах бичгийн нийт үгийн сан

Сурах бичиг тус бүрд буй уран зохиолын нэр томъёоны тоо

Уран зохиолын нэр томъёоны давтамж

Хөмрөгийн үгийн сан ба уран зохиолын нэр томъёоны харьцаа

Сурах бичиг тус бүр дэх уран зохиолын нэр томъёоны залгамж холбоо зэргийг тус тус тооцоолон гаргасан болно.

Нэгдүгээрт, Бид *Монгол хэл I-V* ангийн сурах бичгийн материалд боловсруулалт хийж, анги тус бүрээр хөмрөг үүсгэсэн бөгөөд давхардсан тоогоор нийт 125,207 (Нэг зуун хорин таван мянга хоёр зуун долоо) үгтэй хөмрөг бүрдүүлэв. *Хоёрдугаарт*, Сурах бичгийн хөмрөг тус бүрээс уран зохиолын нэр томъёог бүртгэснээ доорх графикаар үзүүлэв.




График 1. Монгол хэлний I-V ангийн сурах бичиг дэх уран зохиолын нэр томъёоны хэмжээ

Монгол улсын ЕБС-ийн бага ангийн монгол хэлний сурах бичиг дэх уран зохиолын нэр томъёог бүртгэхэд нийт 58 нэр томъёо байгаагаас *Монгол хэл I* сурах бичигт, *ертөнцийн гурав, зүйр цэцэн үг, оньсого, сургаал үг, таавар, түргэн хэллэг, үлгэр, шүлэг* гэсэн найм; *Монгол хэл II* сурах бичигт, *баатар, бадаг, дүр, ертөнцийн гурав, зугаа үг, зүйр үг, зүйр цэцэн үг, мөр, наадгай, оньсого, өгүүллэг, сургамжит өгүүллэг, сэдэв, таавар, үгэн тоглоом, үлгэр, шүлэг, эсрэг утгатай үг* гэсэн арван найм; *Монгол хэл III* сурах бичигт, *баатар, бадаг, далд утга, домог, домог үлгэр, дүр, ертөнцийн гурав, захидал, зохиогчийн үг, зохиолч, зугаа үг, зүйр цэцэн үг, мөр, ойролцоо утгатай үг, оньсого, өгүүллэг, өгүүлэгч, сэдэв, үлгэр, шүлэг, эсрэг утгатай үг* гэсэн хорин хоёр; *Монгол хэл IV* сурах бичигт, *адилтгал, айзам, амьдчилал, баатар, бадаг, далд утга, домог, дуу, дүр, ёгт үлгэр, ертөнцийн гурав, захидал, зохиогч, зохиолч, зохиолын орчин, зүйр үг, зүйр цэцэн үг, зүйрлэл, мөр, ойролцоо утгатай үг, оньсого, өгүүллэг, салаа утгатай үг, сургаал, сургаалын зохиол, сургамжит өгүүллэг, сэдэв, таавар, толгой холбох, үлгэр, үндсэн утга, хөрөг дүр, хүншүүлэл, хэлц үг, хэмнэл, шилжсэн утга, шог зохиол, шүлэг, эсрэг утгатай үг* гэсэн дөчин нэг; *Монгол хэл V* сурах бичигт, *адилтгал, баатар, багасгал, бадаг, далд утга, домог, дүр, жүжгийн зохиол, жүжиг, захидал, зохиогч, зохиолч, зөгнөлт өгүүллэг, зүйр цэцэн үг, ил утга, ихэсгэл, намтар, оньсого, өгүүллэг, өгүүлэгч, сургаал, сэдэв, үзэгдэл, үлгэр, хүншүүлэл, хүүхдийн жүжиг, хэлц үг, хэтрүүлэл, шүлэг* гэсэн хорин найман нэр бүхий давхардсан тоогоор 117 төрлийн нэр томъёо байна.

Гуравдугаарт, ЕБС-ийн бага ангийн сурах бичгүүд дэх уран зохиолын нэр томъёоны давтамжийг анги тус бүрээр гаргавал дараах байдалтай байна.



График 2. Нэгдүгээр ангийн сурах бичиг дэх уран зохиолын нэр томъёоны хэрэглээ



График 3. Хоёрдугаар ангийн сурах бичиг дэх уран зохиолын нэр томъёоны хэрэглээ



График 4 (Гуравдугаар ангийн сурах бичиг дэх уран зохиолын нэр томъёоны хэрэглээ)



График 5 (Дөрөвдүгээр ангийн сурах бичиг дэх уран зохиолын нэр томъёоны хэрэглээ)



График 6 (Тавдугаар ангийн сурах бичиг дэх уран зохиолын нэр томъёоны хэрэглээ)

Дөрөвдүгээрт, Судалгаанаас харахад Монгол хэл I сурах бичигт 8 төрлийн 36, Монгол хэл II сурах бичигт 18 төрлийн 258, Монгол хэл III сурах бичигт 22 төрлийн 473, Монгол хэл IV сурах бичигт 41 төрлийн 493, Монгол хэл V сурах бичигт 28 төрлийн 729, нийт 1989 уран зохиолын нэр томъёо байна. Монгол хэл I-IV ангийн сурах бичгүүд дэх уран зохиолын нэр томъёоны тоо хэмжээ анги ахих тусам найм, арван найм, хорин хоёр, дөчин нэг болж өссөн бөгөөд Монгол хэл V ангид 28 болж нэр төрлийн хувьд буурсан үзүүлэлттэй байгаа нь ажиглагдав.



Тавдугаарт, Сурах бичгүүдэд хэрэглэж буй уран зохиолын нэр томьёоны хэрэглээг тодорхойлохын тулд тухайн нэр томьёо хэдэн сурах бичигт илэрч байгааг анхаарвал дараах байдалтай байна.

№	Сурах бичгийн тоо	Нэр томьёо
1	Нэг сурах бичигт	Айзам, амьдчилал, багасгал, домог үлгэр, дуу, ёгт үлгэр, жүжгийн зохиол, жүжиг, зохиогчийн үг, зохиолын орчин, зөгнөлт өгүүллэг, зүйрлэл, ил утга, ихэсгэл, наадгай, намтар, салаа утгатай үг, сургаал үг, сургаалын зохиол, сургамжит үлгэр, толгой холбох, түргэн хэллэг, үгэн тоглоом, үзэгдэл, үндсэн утга, хөрөг дүр, хүүхдийн жүжиг, хэмнэл, хэтрүүлэл, шилжсэн утга, шог зохиол
2	Хоёр сурах бичигт	Адилтгал, зугаа үг, зүйр үг, ойролцоо утгатай үг, өгүүлэгч, сургаал, сургамжит өгүүллэг, хүншүүлэл, хэлц үг, таавар
3	Гурван сурах бичигт	Бадаг, далд утга, домог, захидал, зохиолч, мөр, эсрэг утгатай үг, зохиогч
4	Дөрвөн сурах бичигт	Баатар, дүр, ертөнцийн гурав, өгүүллэг, сэдэв
5	Бүх сурах бичиг	Зүйр цэцэн үг, оньсого, үлгэр, шүлэг

Хүснэгт 1. Сурах бичиг дэх уран зохиолын нэр томьёоны хэрэглээ

Дээрх хүснэгтээс үзвэл Монгол хэлний I-V ангийн сурах бичигт байгаа уран зохиолын нийт 58 нэр томьёоны 31 нь буюу 53 хувь нь зөвхөн нэг сурах бичигт орсон бол, 10 нь буюу 17 хувь нь хоёр сурах бичигт, 8 нь буюу 14 хувь нь гурван сурах бичигт, 5 нь буюу 9 хувь нь дөрвөн сурах бичигт орсон байна. Харин бүх сурах бичигт тогтвортой хэрэглэгдэж буй зүйр цэцэн үг, оньсого, үлгэр, шүлэг гэсэн 4 нэр томьёо нийт 7 хувийг эзэлж байна.

Судалгааны үр дүн

Тус судалгаанд Монгол хэлний I-V ангийн сурах бичгийн нийт үгийн сан, сурах бичиг тус бүрд буй уран зохиолын нэр томьёоны тоо, давтамжийг гарган, хөмрөгийн үгийн сан ба

уран зохиолын нэр томъёоны харьцаа, хэрэглээний тогтвортой байдал зэргийг тодорхойлсноо хураангуйлбал,

Нэгдүгээр ангийн 6780, хоёрдугаар ангийн 20430, гуравдугаар ангийн 28639, дөрөвдүгээр ангийн 38435, тавдугаар ангийн 30923, нийт 125,207 үгтэй сурах бичгийн хөмрөг үүсгэлээ.

Монгол хэл I сурах бичигт 8 төрлийн 36, *Монгол хэл II* сурах бичигт 18 төрлийн 258, *Монгол хэл III* сурах бичигт 22 төрлийн 473, *Монгол хэл IV* сурах бичигт 41 төрлийн 493, *Монгол хэл V* сурах бичигт 28 төрлийн 729, нийт 1989 уран зохиолын нэр томъёо давтагдсан нь бүртгэгдлээ.

Бүрдүүлсэн хөмрөгт байгаа давхардаагүй 58 нэр томъёоны 31 нь буюу 53 хувь нь зөвхөн нэг, 10 нь буюу 17 хувь нь хоёр, 8 нь буюу 14 хувь нь гурав, 5 нь буюу 9 хувь нь дөрөв, 4 нэр томъёо нийт 7 хувь нь таван сурах бичигт оржээ.

Үүнээс гадна дээр дурдсан 58 нэр томъёонд ороогүй жигдэлбэл зохих, цаашид анхаарч үзэх хэд хэдэн асуудал байна. Үүнд:

Нэгдүгээрт, Бага ангийн сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан аливаа нэр томъёог тогтсон журмын дагуу тогтвортой хэрэглэх ёстой нь зүйн хэрэг боловч бидний хэрэглэгдэхүүн болсон сурах бичгүүдэд “Онъсогог өгүүллэг”, “Онъсогог өгүүллэг” зэрэг үгс байгааг адил ойлголт гэж үзвэл жигдлэх, хэрэв өөр ойлголт гэж үзвэл тодруулан тайлбарлах хэрэгтэй болов уу.

Хоёрдугаарт, Уран зохиолын үндсэн нэр томъёог тогтсон онолын дагуу сурах бичигт оруулж сурагчдад төөрөгдөл үүсгэлгүй мэдлэг бүтээхэд туслах нь сурах бичгийн үндсэн зорилгын нэг гэж үзэж болно. Хэдий ийм боловч бидний бүрдүүлсэн Монгол хэлний сурах бичгийн хөмрөгт мөн зөрүүтэй нэр томъёо байна. Ш.Гаадамба, Х.Сампилдэндэв, Д.Цэрэнсодном нар “Монгол ардын аман зохиол” (1988) бүтээлдээ, Ш.Гаадамба “Зүйр цэцэн үгийг зүйлчлэн ангилах асуудалд” өгүүлэлдээ (1969) зүйр цэцэн үгийг бүтээх арга журмын онцлогоор нь цэцэн үг, зүйр үг, мэргэн үг гэж ангилсан ангиллыг утга зохиолын онолд мөрдлөг болгодог ёсоор үзвэл “зүйр үг” гэсэн нэр томъёог II, IV ангийн сурах бичгүүдэд, “зүйр цэцэн үг” гэсэн нэр томъёог бүх сурах бичигт давхардуулж оруулсныг жигдлэх шаардлагатай.

Гуравдугаарт, Дээрх сурах бичгүүдэд зохиогч, зохиолын нэр, зохиолын төрлүүдийг зарим газарт бүрэн, зарим газар хагас дутуу бичиж орхигдуулах байдал нэлээд тохиолдож байна. Сурагчдад цэгцтэй мэдлэг олгоход сурах бичиг тус бүрийн нэр томъёо, ухагдахууныг жигдлэн, хэрэглээнд хэвшүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Дүгнэлт

Бид тус өгүүллийн хүрээнд ЕБС-ийн I-V ангийн Монгол хэлний сурах бичгийн нийт 125,207 үгийн сантай цахим сан үүсгэсэн бөгөөд цахим сангийн уран зохиолын нэр томъёоны нарийвчилсан судалгаа хийв. Цаашид монгол хэлний сургалтын хөтөлбөр, сурах бичиг, гарын авлага, нэр томъёоны толь бичиг хийгээд түвшин тогтоох шалгалтын материалыг бэлтгэх, боловсруулахад дээрх судалгааны үр дүн чухал үүрэгтэй гэж дүгнэж байна. Түүнчлэн цахим сан бүрдүүлэх арга зүй, программ хангамжийг хэрэглээнд нэвтрүүлж, баримт тооцоонд суурилсан судалгааг хийх нь сурах бичиг, уран зохиол төдийгүй нэр томъёо хэрэглээний судалгааг улам боловсронгуй болгох ач холбогдолтой юм.

Abstract

This paper aimed to define the sustainable use of the terminology of literature. To reach the aim, we created the electronic source of the vocabulary of textbooks of 1-5 grades of general education schools Mongolian language textbooks using the Cyrillic Mongolian writing program of phonetic transcription which was built by School of Applied Science and Engineering of National University of Mongolia (Ch.Altangerel, J.Purev) and AntConc software (Laurence Anthony) of Japan. Based on the electronic source of vocabulary, we registered the terminology of literature, calculated the frequency of terminology, and compared the textbooks of the same grades as well as different grades.

Номзүй

- Алтангэрэл Ч., Энхжаргал М. 2013. *Цахим бичвэрт суурилсан монгол хэлний үеийн давтамжийн судалгаа*. Монгол судлал. XXXVI (386): 1-10. (Altangerel, Ch., Enkhjargal, M. (2013). *Computer based study of Syllable Frequency of Mongolian*. Монгол судлал, XXXVI (386):1-10).
- Бямбацэрэн Г., Болормаа Г., Лхамноржмоо Б., Хажидмаа В. 2020. *Монгол хэл II (долоо дахь хэвлэл)*. Улаанбаатар.
- Галбаатар Д. 2012. *Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл*. Улаанбаатар.
- Дулам С., Нандинбилиг Г. 2020. *Монголын аман зохиолын онол-II*. Улаанбаатар.
- Одсүрэн П., Гэрэлсайхан Б., Даваасүрэн Н., Дашдолгор Ц. 2020. *Монгол хэл IV (долоо дахь хэвлэл)*. Улаанбаатар.
- Олзвой Л., Оюунцэцэг Б., Энхжаргал М., Оюунцэцэг Ш. 2020. *Монгол хэл V (долоо дахь хэвлэл)*. Улаанбаатар.
- Оюунцэцэг Ш., Хадаа Ө., Цогцолмаа Д., Энхтуяа Т. 2020. *Монгол хэл I (долоо дахь хэвлэл)*. Улаанбаатар.
- Цэндсүрэн Ө., Бигэрмаа Р., Жаргалсайхан П., Нямхүү У. 2020. *Монгол хэл III (долоо дахь хэвлэл)*. Улаанбаатар.
- Энхжаргал С., Боролзой Д. 2017. *Эх хэлний боловсролын асуудалд*. Улаанбаатар.
- Sandra Kubler., Heike Zinsmeister. 2015. *Corpus linguistics and Linguistically annotated Corpora*. London.